



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/103

Улаанбаатар хот

“Буянт-Ухаа” Олон улсын нисэх  
буудлын дүрэмд өөрчлөлт  
оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын үйл ажиллагаа эхлэх, “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын үйл ажиллагаа, зохион байгуулалтад өөрчлөлт оруулахтай холбогдуулан Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын 2020 оны “Дүрэм батлах тухай” А/109 дүгээр тушаалаар баталсан “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын дүрмийн 6.3.2 дахь заалтаар тус нисэх буудлын захиралд олгогдсон “ажилтныг томилох, чөлөөлөх, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, цуцлах, дуусгавар болгох” эрхийг түдгэлзүүлсүгэй.

2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан тус нисэх буудлын ажилтнуудыг ажилд томилох, чөлөөлөх, хөдөлмөрийн гэрээ байгуулах асуудлыг Иргэний нисэхийн үндэсний төвд тавьж шийдвэрлүүлэхийг “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудал (Д.Мөнхбаатар)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтэс (Л.Тайванжаргал)-т даалгасугай.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ

1721 01 0834